



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНД, СПОРТЫН САЙДЫН ТУШААЛ

2016 оны 07 сарын 20 өдөр

Дугаар А/294

Улаанбаатар хот

Г

Г

Эмгэг судлалын үндэсний төвийн дүрэм,
бүтцийг шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 4-т, Эрүүл мэндийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь хэсэгт тус тус заасныг үндэслэн ТУШААХ нь:

1. "Эмгэг судлалын үндэсний төвийн дүрэм"-ийг нэгдүгээр, зохион байгуулалтын бүтцийг хоёрдугаар, холбогдох эрүүл мэндийн байгууллагыг мэргэжил, арга зүйгээр хангах ерөнхий зураглалыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Шинэчлэн батлагдсан дүрэм, зохион байгуулалтын бүтцийг мөрдлөг болгон ажиллахыг Эмгэг судлалын үндэсний төвийн захирал (Г.Уянга)-д үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга (А.Эрдэнэтуяа)-д даалгасугай.

4. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайдын 2013 оны 434 дүгээр тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД



С.ЛАМБАА

081099

Эрүүл мэнд спортын сайдын
2016 оны 07 сарын 20 өдрийн
А/294 дугаар тушаалын 1 дүгээр
хавсралт



ЭМГЭГ СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Эмгэг судлалын үндэсний төв нь (цаашид Төв гэх) улсын хэмжээнд эмгэг судлалын үндсэн мэргэшлээр лавлагаа тусламж, үйлчилгээ үзүүлэх чиг үүрэг бүхий тусгай мэргэжлийн төв мөн.

1.2. Төв нь эмгэг эд, эс, бүтэц судлал, онош зүй, лабораторийн шинжилгээний аргуудад тулгуурлан эмгэг судлалын онош тавьж, эрүүл мэндийн байгууллагад ажиллаж буй эмнэлзүйн эмч нарын оношлогоо, эмчилгээ, үйлчилгээний чанарыг дээшлүүлэх, сургалт, судалгаа, эрдэм шинжилгээний ажил хийх, эмгэг судлалын тусламж, үйлчилгээг улсын хэмжээнд мэргэжил, арга зүйгээр хангах, байгууллагын хөгжлийн хэтийн төлөв, бодлого боловсруулах зорилго бүхий эрүүл мэндийн байгууллага мөн.

1.3. Төв нь Монгол Улсын Үндсэн хууль, Эрүүл мэндийн тухай хууль, Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомж, тэдгээртэй нийцүүлэн гаргасан дүрэм, журам, стандартад заасны дагуу үйл ажиллагаагаа явуулна.

1.4. Төв нь холбогдох хууль тогтоомжийн дагуу үйлдсэн тамга, тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас болон билэгдэл, санхүүгийн харилцах данстай байна.

1.5. Төв нь Эмгэг судлалын үндэсний төв, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Энхтайвны өргөн чөлөө-13 хаягтай байна.

1.6. Төвийн нэрийг англи хэл дээр "National Center for Pathology" гэж нэрлэнэ.

Хоёр. Төвийн үйл ажиллагааны баримтлах зарчим, зорилго, үнэт зүйлс

2.1. Төв нь үйл ажиллагаандаа дараах зарчмыг баримтална. Үүнд:

- Үйлчлүүлэгчийг дээдлэх;
- Үйлчлүүлэгч бүрт эрх тэгш хандах;
- Хувь хүний эрүүл мэндтэй холбоотой нууцыг хамгаалах, задруулахгүй байх;
- Тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг хангах;
- Тусламж, үйлчилгээтэй холбоотой шийдвэрийг нотолгоонд суурилан гаргах;
- Тусламж, үйлчилгээг иргэдэд чирэгдэлгүй, шуурхай зохион байгуулах;
- Ил тод, нээлттэй байж иргэд, байгууллагад шаардлагатай мэдээллээр хангах;
- Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээг чанд мөрдөх;

2.2. Төвийн эрхэм зорилго:

Монгол Улсын эмгэг судлалын шинжлэх ухааны тэргүүлэгч байгууллага байхад оршино.

2.3. Төвийн үнэт зүйлс:

- Мэргэшсэн, ёс зүйтэй, ур чадвартай хүний нөөц
- Тэгш хүртээмжтэй, чанартай, аюулгүй тусламж, үйлчилгээ

Гурав. Төвийн эрх, үүрэг

3.1. Төв нь дараах эрхтэй:

3.1.1. Төвийн эрхэм зорилго, зорилт, үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд хамт олон, төрийн болон төрийн бус байгууллага, иргэдийн оролцоог дээшлүүлэх, хамтран ажиллах;

3.1.2. Эмгэг судлалын тусламж, үйлчилгээтэй холбоотой мөрдөгдөх баримт бичгийн төслийг боловсруулах, санал өгөх;

3.1.3. Төвийн чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардлагатай бүтэц, хүний нөөцийг бүрдүүлж, хууль тогтоомжид заасны дагуу төсвийг захиран зарцуулах;

3.1.4. Ижил чиг үүрэг бүхий гадаадын байгууллагатай хамтын ажиллагааг өргөжүүлэн эмгэг судлалын тусламж, үйлчилгээг сайжруулах, байгууллага болон хүний нөөцийг чадавхижуулах чиглэлээр хамтарсан төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх, харилцан туршлага солилцох;

3.1.5. Судалгаа, шинжилгээний ажил хийх, үндэсний болон олон улсын эрдэм шинжилгээний хурал, сургалтыг зохион байгуулах, оролцох;

3.1.6. Гадаад, дотоодын төрийн болон төрийн бус байгууллага бусад хувийн хэвшлийн байгууллага, иргэдтэй хамтран ажиллах;

3.1.7. Эмгэг судлалын тусламж, үйлчилгээг чанартай, хүртээмжтэй, стандартын дагуу үзүүлэхэд шаардлагатай бодис урвалж, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, хөрөнгө оруулалтын асуудлаар төрийн захиргааны төв байгууллагад нотолгоонд суурилсан санал боловсруулан тавьж, шийдвэрлүүлэх;

3.1.8. Хууль тогтоомж болон төрийн захиргааны төв байгууллагаас гаргасан шийдвэрийн дагуу эмгэг судлалын зарим тусламж, үйлчилгээг төлбөртэй үзүүлэх;

3.1.9. Хууль тогтоомжоор олгогдсон бусад эрх.

3.2. Төв нь дараах үүрэгтэй:

3.2.1. Улсын хэмжээнд эмгэг судлалын тусламж, үйлчилгээний бодлогыг хэрэгжүүлж, эрүүл мэндийн бусад байгууллагыг мэргэжил, арга зүйгээр хангах;

3.2.2. Амьд ахуйн эд, эсийн шинжилгээ, эмгэг судлалын задлан шинжилгээ хийх, эмнэлзүй эмгэг судлалын лавлагаа тусламж, үйлчилгээг үзүүлэх, урьдчилан сэргийлэх, эрт илрүүлгийн эсийн шинжилгээний баталгаажилтыг хийх;

3.2.3. Тусламж, үйлчилгээг сайжруулах, тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх арга хэмжээний саналыг боловсруулан эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгуулагад танилцуулах;

3.2.4. Эмгэг судлалын чиглэлээр эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах сургалт эрхлэх;

3.2.5. Эмгэг судлалын тусламж, үйлчилгээний чанарыг сайжруулах, аюулгүй байдлыг хангах, оношлогооны дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлэх;

3.2.6. Эмгэг судлалын чиглэлээр цахим мэдээллийн сан бүрдүүлж төрийн захиргааны төв байгууллага болон холбогдох бусад байгууллагыг мэдээллээр хангах;

3.2.7. Мэдээллийн технологийн дэвшлийг нэвтрүүлэн, эмгэг судлалын зайн оношлогоог хөгжүүлэх;

3.2.8. Иргэдэд эмгэг судлалын үйл ажиллагааг мэдээлэх;

3.2.9. Эмгэг судлалын тусламж, үйлчилгээний талаар иргэдээс санал, хүсэлт, гомдлыг хүлээн авч, хууль тогтоомжид заасны дагуу шуурхай шийдвэрлэх;

3.2.10. Байгууллагын үйл ажиллагаанд олон улсын түвшний итгэмжлэл авах;

3.2.11. Санхүү, төсвийн нээлттэй, ил тод зарчмыг баримтлах, төсвийг үр ашигтай төлөвлөх, зарцуулах;

3.2.12. Тусламж, үйлчилгээний онцлогийг тусгасан эрсдэлийн удирдлагын журам боловсруулан, хэрэгжүүлэх;

3.2.13. Ажиллагсдын нийгмийн баталгааг хангах, ажлын байрны нөхцлийг сайжруулах талаар хөтөлбөр, төсөл хэрэгжүүлэн санаачлагатай ажиллах;

3.2.14. Ажиллагсдын мэргэжил, ур чадварт тохирсон цалин хөлс олгож, мэргэжил, мэдлэг, ур чадварын түвшинг тасралтгүй дээшлүүлж, эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээг мөрдүүлж ажиллах;

3.2.15. Хууль тогтоомжид заасан бусад үүрэг.

Дөрөв. Төвийн бүтэц, удирдлага зохион байгуулалт

4.1. Төвийн удирдлагын тогтолцоо нь захирал, Удирдлагын зөвлөлөөс бүрдэнэ. Төв нь бодлого, төлөвлөлтийн алба, чанарын алба, эмгэг судлалын тусламж, үйлчилгээний алба, эс судлалын эрт илрүүлгийн алба, санхүү, эдийн засгийн алба, судалгаа шинжилгээ, сургалт, гадаад харилцааны албанаас бүрдэнэ.

4.2. Төв нь судалгаа, шинжилгээний ажлын хэтийн болон ойрын зорилт, тэргүүлэх чиглэлийг тодорхойлох, судалгаа, шинжилгээний сэдэв, арга зүй, явц, үр дүнг хэлэлцэн, тэдгээрт үнэлэлт, дүгнэлт өгөх үүрэг бүхий Эрдмийн зөвлөл байгуулан ажиллуулна. Эрдмийн зөвлөлийн дүрэм, бүрэлдэхүүнийг захирал батална.

4.3. Төвийн захирлын шийдвэр нь тушаал, Удирдлагын зөвлөл, Эрдмийн зөвлөлийн шийдвэрүүд нь хурлын тэмдэглэл хэлбэртэй байна.

4.4. Төв нь дэргэдээ Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн салбар хороо болон бусад шаардлагатай хороог ажиллуулж болно.

4.5.Захирлын эрх, үүрэг:

4.5.1. Төвийг удирдлага, зохион байгуулалтаар хангах, төвийг бүрэн хэмжээгээр төлөөлөх, үйл ажиллагааны үр дүнг хариуцах;

4.5.2. Төвийн үйл ажиллагааны чиглэл, чиг үүрэг, байгууллагын дотоод журам, ойрын болон хэтийн хөгжлийн төлөвлөгөөг батлах, хэрэгжилтэнд хяналт тавих;

4.5.3. Батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төвийн орон тоо, ажиллагсдын цалин хөлсийг тогтоох;

4.5.4. Холбогдох хууль тогтоомжид заасны дагуу ажилтныг томилох, чөлөөлөх, хариуцлага ногдуулах;

4.5.5. Захирал нь төвийн холбогдох албаны удирдлага, албан тушаалтныг оролцуулсан Удирдлагын зөвлөлийг байгуулж, ажиллах журмыг батлах;

4.5.6. Байгууллагын жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөг батлан, хэрэгжилтийн тайланг хамт олны хурлаар хэлэлцүүлэн, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр мэдээлэх;

4.5.7. Ажилтнуудын ажлын байрны тодорхойлолтыг батлан, хөдөлмөрийн гэрээ байгуулах, дүгнэх, гэрээг цуцлах;

4.5.8. Төсвийн ерөнхийлөн захирагчтай жил бүр үйл ажиллагааны үр дүнгийн гэрээ байгуулж, биелэлтийг ханган ажиллах;

4.5.9. Удирдах ажилтны ёс зүйг чанд сахиж, авилгаас ангид ажиллах;

4.5.10. Байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийн үнэн зөв байдлыг хариуцах;

Тав. Төвийн санхүүжилт

5.1.Төвийн санхүүжилт нь дараах эх үүсвэрээс бүрдэнэ. Үүнд:

5.1.1. Улсын төсөв;

5.1.2. Үндсэн болон туслах үйл ажиллагааны орлого;

5.1.3. Төсвийн тухай хуульд заасан журмын дагуу Монгол Улсын болон гадаадын иргэн, хуулийн этгээд, хувь хүний хандив, тусламж;

5.1.4. Олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөрийн санхүүжилт;

5.1.5. Хууль тогтоомжид заасан бусад эх үүсвэр.

Зургаа. Төвийн гадаад, дотоод хамтын ажиллагаа

6.1. Төвийг гадаад, дотоодын хамтын ажиллагаанд Захирал төлөөлнө.

6.2. Төвийн Захирлын гадаад оронд туршлага судлах, мэргэжлийн сургалтанд суралцах, хурал, семинарт оролцох албан томилолт, удирдамжийг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнээр шийдвэрлүүлнэ.

6.3. Төвийн ажилтны гадаад, дотоод албан томилолтыг захирал, суралцах асуудлыг Удирдлагын зөвлөл шийдвэрлэнэ.

6.4. Төв нь төрийн захиргааны төв байгууллагын удирдлага, газрын дарга нартай шууд харилцаж, эрүүл мэндийн талаарх төрийн бодлого, хууль тогтоомжийг биелүүлэх ажлыг зохион байгуулахдаа чиглэл, үүрэг, зөвлөмж авч үйл ажиллагаагаа уялдуулан ажиллана.

6.5. Төв нь өөрийн эрхлэх асуудлаар бусад эрүүл мэндийн байгууллага, төрийн болон төрийн бус байгууллага, иргэдтэй шууд харилцана.

Долоо. Төвийн үйл ажиллагааны чиг үүрэг

7.1. Эмгэг судлалын тусламж, үйлчилгээний алба

7.1.1. Алба нь амьд ахуйн эд, эсийн шинжилгээний оношилгоо болон эмнэлгийн нас баралтад эмгэг судлалын задлан шинжилгээ хийх, дүгнэлт гаргах, эмнэлзүй, эмгэг судлалын эмч нарын хамтарсан зөвлөгөөн хийх чиг үүргийг хэрэгжүүлнэ.

7.1.2. Алба нь үндсэн үйл ажиллагааны лавлагаа лаборатори, насанд хүрэгсэд болон хүүхдийн гэсэн хэсгээс бүрдэнэ.

7.1.3. Лавлагаа лабораторийн хэсэг нь нь эд судлал, эс судлал, иммуногистохими, экспресс шинжилгээ, молекул генетик, бактериологи, туршилт судалгааны ажил хийх;

7.1.4. Сургалт зохион байгуулах;

7.1.5. Эмгэг судлалын чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж буй лабораториудад чанарын гадаад үнэлгээний үйл ажиллагааг хэрэгжүүлэх;

7.1.6. Эмгэг эд, эсийн лабораториудад сорьц цуглуулах, бэлтгэн боловсруулах, шинжлэх, хадгалах;

7.2. Эс судлалын эрт илрүүлгийн алба

7.2.1. Эс судлалын эрт илрүүлгийн шинжилгээнд баталгаажилт өгөх;

7.2.2. Улсын хэмжээнд эсийн эмгэг судлаач эмч, эс судлалын лабораторийн техникч нарыг мэргэжил, арга зүйгээр хангах;

7.2.3. Эс судлалын шинжилгээнд чанарын хяналтыг хийж гүйцэтгэх;

7.2.4. Зайн оношилгооны ашиглалтыг нэмэгдүүлэх, нэгдсэн мэдээллийн сан бүрдүүлэх;

7.3. Чанарын алба

7.3.1. Алба нь Эрүүл мэндийн тухай хууль болон бусад хууль тогтоомж, төвийн захирлын баталсан тушаал, шийдвэр, албан даалгавар, заавар, дүрэм, журмыг баримтлан, төвийн хэмжээнд эмгэг судлалын тусламж, үйлчилгээний чанарын удирдлагын тогтолцоонд нийцүүлэн чанарыг тасралтгүй сайжруулах үйл ажиллагааг

зохион байгуулах, чанар, аюулгүй байдалд дотоод хяналт тавих үндсэн үүргийг гүйцэтгэнэ.

7.3.2. Эмгэг судлаач эмч нарын эмгэг судлалын протоколын бичилт, амьд ахуйн эд, эсийн шинжилгээний онош, дүгнэлт, лаборант нарын бичиг баримтын хөтлөлт, гистологи бэлдмэл болон эмнэлгийн бусад ажилтнуудын ажлын гүйцэтгэлд чанарын хяналт тавих;

7.3.3. Илэрсэн зөрчлийг арилгуулах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, эмгэг судлалын тусламж, үйлчилгээний аюулгүй байдлыг хангуулах, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар мэргэжил, арга зүйн зөвлөмж, зөвлөгөө өгч, санал боловсруулж ажиллах;

7.4. Санхүү, эдийн засгийн алба

7.4.1. Алба нь төвийн нягтлан бодох бүртгэлийг санхүүгийн тайлангийн олон улсын стандарт, Монгол Улсад мөрдөж буй Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль бусад холбогдох хууль тогтоомжтой нийцүүлэн, харилцагч, хэрэглэгчийн шийдвэр гаргахад ач холбогдолтой, үнэн, зөв мэдээллээр удирдлагыг хангаж, шилэн дансны мэдээллийг хариуцах болон бусад санхүүгийн мэдээллийг цуглуулах, бүртгэх, тайлагнах, тодруулга бэлтгэх ажлыг зохион байгуулах, эд хөрөнгийн бүртгэл, хяналт, хадгалалт, хамгаалалтын үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

7.4.2. Байгууллагын төсвийн жил болон дунд хугацааны хөрөнгө оруулалтын арга хэмжээ, төсвийн төслийг боловсруулах, байгууллагын үйл ажиллагааны үр дүн, үйл ажиллагааны нэгжийн өртөг зардлыг тооцох, төсвийн үр ашгийг сайжруулах арга хэмжээг авах, дээрх чиглэлээр байгууллагын удирдлагыг мэдээллээр хангах;

7.4.3. Хангамж, үйлчилгээтэй холбоотой төвийн барилга, эд хогшил, автомашин, тоног төхөөрөмж, мэдээлэл, холбооны хэрэгслийн хэвийн үйл ажиллагааг хангах, засвар үйлчилгээг хийх, засвар үйлчилгээний холбогдолтой мэдээллийн сан байгуулж, гадаад болон дотоод орчны тохижилт, цэвэрлэгээ үйлчилгээг хийх, байгууллагын харуул хамгаалалт, аюулгүй байдлыг хангах;

7.5. Сургалт, судалгаа, эрдэм шинжилгээ, гадаад харилцааны алба

7.5.1. Алба нь сургалт, судалгаа, эрдэм шинжилгээ, гадаад харилцааг төвийн хэмжээнд зохион байгуулах ажлыг хариуцна.

7.5.2. Судалгаа, эрдэм шинжилгээний ажлыг зохион байгуулах, мэдээний сан үүсгэх, олон улсад нэвтэрч буй анагаах ухааны ололт, амжилтыг нэвтрүүлэх санал, зөвлөмж боловсруулах;

7.5.3. Эрүүл мэндийн сургалт, сурталчилгаа зохион байгуулах, төрийн болон төрийн бус байгууллага, олон нийт, иргэний нийгмийн байгууллага, иргэдтэй хамтран ажиллах;

7.5.4. Эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах сургалтыг эрхлэх;

7.5.5. Оношлогооны дэвшилтэт арга, технологийн чиглэлээр гадаад харилцааг өргөжүүлэх, хамтарсан төсөл хэрэгжүүлэх, төсөл, хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулах, харилцан туршлага солилцох, олон улсын эрдэм шинжилгээний хурал, сургалт, семинарыг зохион байгуулах, оролцох;

7.6. Бодлого, төлөвлөлтийн алба

7.6.1. Алба нь төвийн алсын хараа, хэтийн зорилгыг үйл ажиллагааны үндсэн чиглэлтэй уялдуулан тодорхойлж, түүнийг хэрэгжүүлэх, байгууллагын төлөвлөгөөг эрүүл мэндийн салбарын хэмжээнд дэвшүүлсэн бодлого, шийдвэртэй нийцүүлэн боловсруулах, төвийн эрхлэх асуудлын хүрээнд үндэсний хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилтийг манлайлан зохион байгуулах, байгууллагын дотоод журам, жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулах, тайлагнах, дээрх чиглэлээр байгууллагын удирдлагыг мэдээллээр хангах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

7.6.2. Төвийн хүний нөөцийн хөгжлийн төлөвлөгөөг боловсруулах, ажилтнуудын ажлын байрны тодорхойлолтыг боловсруулах, ажилтны нийгмийн баталгааг хангахад чиглэгдсэн үйл ажиллагааг хэрэгжүүлэх;

7.6.3. Эмгэг судлалын тусламж, үйлчилгээний статистик мэдээ, мэдээллийг цуглуулах, бүртгэх, мэдээлэх, тайлагнах, мэдээний сан үүсгэх;


Найм. Дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах

8.1. Төвийн захирлын саналыг үндэслэн эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шийдвэрээр дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулна.

Эрүүл мэнд, спортын сайдын 2016 оны
07 дугаар сарын 20-ны өдрийн 18 дугаар
тушаалын хоёрдугаар хавсралт




Эмгэг судлалын үндэсний төвийн бүтэц



Эрүүл мэнд, спортын сайдын 2016 оны
07 дугаар сарын 20-ны өдрийн 4/20 дугаар
тушаалын гуравдугаар хэвсрэлт



Эмгэг судлалын үндэсний төвөөс
холбогдох эрүүл мэндийн байгууллагыг мэргэжил,
арга зүйгээр хангах ерөнхий зураглал



-----> Мэргэжил, арга зүйн шууд бус удирдлага